

Даяаршил хурдацтай явагдаж, улс хоорондын харилцан хамаарал улам нэмэгдэж буй оноо вед тухайн улсын эдийн засгийн аюулгвй байдал оршин буй бвс нутгаасаа шууд хамааралтай болоод байна.

Зввн хойд Азийн бвс нутгийн улс орнууд олон улсын харилцааны орчинд гарч буй оорчлолттэй уялдан эдийн засгийн хамтын ажиллагааг хогжввлж, эдийн засгийн аюулгвй байдлаа хангах нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэхвв тулгамдсан асуудлын хврээнд Зввн хойд Азийн орнуудын эрдэмтэн судлаачдыг оролцуулан бвс нутгийн эдийн засгийн чиглэлээр гаргаж буй олон санал санаачилгуудын хоорондын уялдаа холбоо, ач холбогдол, харилцан хамаарлын шинжлэх ухааны вндэслэлийг хамтран хэлэлцэж, санаа бодлоо нэгтгэх ввднээс Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хврээлэн хамтран 2017 оны 9 двгээр сарын 14-15-ны одрввдэд “Зввн хойд Азийн орнуудын эдийн засгийн аюулгвй байдал, хамтын ажиллагааг хогжввлэх боломж”сэдэвтэрдэм шинжилгээний хурлыг Гадаад харилцааны яамны “Зовшилцол” танхимд зохион байгуулж явууллаа.

Энэхвв эрдэм шинжилгээний хуралд Улсын Их Хурлын Аюулгвй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хорооны ажлын алба, Еронхийлогчийн Тамгын газар, ҮАБЗ-ийн ажлын алба, Монгол Улсад суугаа гадаадын Элчин сайдын яамд, олон улсын дипломат толоологчийн газрын ажилтнууд, ОХУ, БНХАУ, Турк, БНСУ, Япон Улсын батлан хамгаалахын атташе нар, Дэлхийн банкны суурин толоологчийн газар, Олон улсын валютын сан, “Жей Си Эс”, “Adra” зэрэг олон улсын байгууллагын зочид толоологчид, Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Зэвсэгт хвчний Жанжин штабын удирдлага, Монгол банк, Эдийн засгийн бодлого, орсолдох чадварын судалгааны тов, Монголын вндэсний худалдаа, аж вйлдвэрийн танхим, ҮАБЗ-ийн харъяа Стратегийн судалгааны хврээлэн, ШУА-ийн харъяа Олон улсын харилцааны хврээлэн, Гео бодлого судлалын хврээлэн, МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Үндэсний тагнуулын академи зэрэг сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын эрдэмтэн судлаачдын толоологчид нийт 140 гаруй хвн оролцлоо

Мон хуралд БНХАУ-ын Орчин веийн олон улсын харилцааны хврээлэнгийн дэд захирал, профессор Юань Чон, ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Алс Дорнодын хврээлэнгийн судлаач, доктор, профессор Василий Кашин, Япон Улсын Рицвмэйкан их сургуулийн профессор Мияаваки Нобору болон БНСУ-ын Хууль, эрх звйн хврээлэнгийн профессор

Сон Син Жэ нар уригдан ирж, илтгэл тавилаа.

2017 оны 9 дүгээр сарын 14-ний одрийн хурлыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ нээж үг хэлсэн бөгөөд ҮАБЗ-ийн Ажлын албаны дарга О.Очиржав хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч, баяр хүргэж үг хэлэв.

Энэ одрийн хурлыг Батлан хамгаалахын дэд сайд, яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга Т.Дуламдорж удирдан явууллаа.

Эхний одрийн хурлын тогсголд нээлттэй хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгийг ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Алс Дорнодын хүрээлэнгийн судлаач, доктор, профессор Василий Кашин, Японы Рицүмэйканы их сургуулийн профессор Мияваки Нобору нар удирдан явуулав.

Хэлэлцүүлгээр Зүүн хойд Азийн аюулгүй байдлын орчны оорчлолтийн эдийн засагт үзүүлж буй нолоолол, хамтын ажиллагаа, Монгол-Японы эдийн засгийн түншлэл, Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор зэрэг оргон хүрээг хамарсан асуудлыг хондсон нь хурлын зорилго, зорилтод бүрэн нийцсэн, ихээхэн ач холбогдолтой хэлэлцүүлэг болов.

Хурлын дараа толоологчид Монгол цэргийн музейн үзэсгэлэн, БЦДБЧ-ын тоглолтыг үзэж сонирхов.

2017 оны 9 дүгээр сарын 15-ны одрийн хурлыг Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг удирдан явуулсан бөгөөд УИХ-ын гишүүн Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга С.Чинзориг, Ерөнхийлогчийн Тамгын газрын дэд дарга Б.Саруул нар хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэн баяр хүргэж, үг хэлэв.

Хэлэлцүүлгийг БНХАУ-ын Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэнгийн дэд захирал, профессор Юань Чон болон БНСУ-ын Хууль, эрх зүйн хүрээлэнгийн профессор, доктор Сон Син Жэ нар удирдан явуулав.

Хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын Засгийн Газраас эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд гадаадын хоронго оруулалтыг татах, нэмэгдүүлэх, гадаад худалдаа, эдийн засгийг оргожүүлэн хөгжүүлэх, худалдааг хонговчлох, гадаадын хоронго оруулагчид, бизнес эрхлэгчдийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, хоронго оруулагчдын итгэлийг сэргээхэд чиглэсэн хоёр талын болон олон талт ажлуудыг хэрэгжүүлэх, мөн бус нутгийн эдийн засгийн харилцаан дахь Монгол Улсын оролцооны байдал, түүнчлэн Зүүн хойд Азийн болон Ази, Номхон далайн эдийн засгийн бүсчлэлд нэгдэн орсноор Монгол Улс эдийн засгийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх боломжийн талаар ярилцав.

Зүүн хойд Азийн орнуудын эдийн засгийн боломж, цар хүрээ их хэдий ч тулгамдаж буй анхаарал татсан асуудлууд цоонгуй байгааг илтгэгч бүр онцлон тэмдэглэж байв.

Зүүн хойд Азийн эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдаад буй асуудлуудын талаар илтгэгчид, хуралд оролцогчдын дэвшүүлсэн үр дүнтэй, үр ашигтай олон санал санаачилгуудыг сургалт судалгааны эргэлтэд оруулах үүднээс эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүдийг эмхэтгэж, хэрэглэгчдийн гар дээр тавьсан нь хувьсгийн талархлыг хвлээгээд байна.

**Хурлын үйл ажиллагааг MNB, Монгол HD телевиз, БХЯ-ны “Дуулга” телевиз, “Соёмбо” сонин, МОНЦАМЭ агентлаг, Монголын үндэсний радио, news.mn сайтаар олон нийтэд сурталчлав.**